



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/211

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйл, 33 дугаар зүйлийн 33.1, 34 дүгээр зүйлийн 34.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоол, Монгол Улсын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан инженерийн шугам сүлжээтэй бүсэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 8 иргэнд газар олгох асуудлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Р.Машбат- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Д.Чинзориг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Янжин- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн үйл ажиллагааны хөтөлбөр, өргөдөл
гомдол шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн

Г.Нэргүй- Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Энхмаа- Аймгийн газрын харилцаа, барилга, хот төлөвлөлтийн
газрын Кадастрын мэргэжилтэн

С.Мөнх-Эрдэнэ- Иргэний төлөөлөл

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

3.Нямбаяр- Аймгийн газрын харилцаа, барилга, хот төлөвлөлтийн
газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

2.Тус газрыг олгоход тавигдах шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Тавигдах шаардлагыг хангасан иргэдийг хууль журмын дагуу сонгож танилцуулахыг ажлын хэсэг (Р.Машбат)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж 2024
6712010669

Аймгийн Засаг даргын 2024 оны
5 дугаар сарын 02-ны өдрийн А/211
захирамжийн хавсралт

Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй
газар олгоход тавигдах шаардлага

1	Мөрөн сумын иргэн байх
2	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Хот-хөдөөгийн шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд шилжиж ирсэн байх
3	Өөрийн болон гэр бүлийн гишүүний нэр дээр газар эзэмших болон өмчлөлгүй байх /эхнэр, нөхөр, хамтран амьдрагч/
4	Олон ам бүлтэй гэр бүл /олон хүүхэдтэй/
5	35-аас доош настай байх